

ЭРҮҮЛ БИЕ ЭРХЭМ БАЯН

HEALTH IS WEALTH

АМЖИЛТЫН ТҮҮХ

“Монгол Улсад КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг сайжруулахад техникийн туслалцаа үзүүлэх, зорилтод нийцүүлэн тархварзүйн хяналтыг дэмжих нь” төсөл

SUCCESS STORY

“Technical Assistance to Strengthen the COVID-19 Response in Mongolia” project



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Д.Нансалмаа:

МЭДЛЭГ, ТУРШЛАГАА СУМУУДЫНХАА ЭМЧ НАРТАЙ ХУВААЛЦАЖ БАЙНА

Dr.Nansalmaa

SHARES HER SKILLS AND KNOWLEDGE TO PRACTITIONERS WHO WORK IN REMOTE AREA

Намайг Д.Нансалмаа гэдэг. Би Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгчээр 5 дахь жилдээ ажиллаж байна. Манай тасаг эрчимт эмчилгээний 2 эмч, мэдээгүйжүүлгийн нэг эмч, эрчимт эмчилгээний 4 сувилагч, туслах 4 сувилагчтай. Төв аймгийн эрчимт эмчилгээний тасаг насанд хүрэгчдийн 4 ортой ажилладаг. Мөн хүүхдийн 2, нярайн 2 ортой ба нийтдээ амьсгалын 20 аппараттайгаар үйл ажиллагаагаа явуулдаг. Зөвөрийн амьсгалын аппаратаар тоноглон нэг автомашин бий.

My name is Nansalmaa, and I have been working as the head of the Intensive Care Department at the Central Hospital in Tuv aimag for five years. In the intensive care department where I work, there are 2 doctors, an anesthesiologist, 4 intensive care nurses and 4 auxiliary nurses. Our whole department has the capacity of 4 beds for adults, 2 beds for children, 2 beds for infants, 20 ventilators and an ambulance equipped with a mobile respirator.

ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙСАН

Би Хүүхдийг Ивээх Сангийн Эрүүл мэндийн төслөөс зохион байгуулсан “Цар тахлын үеийн эрчимт эмчилгээ, зохиомол амьсгалуулалтын дэвшилтэт технологи арга, аргачлал” сургалтад сувилагчтайгаа хамт оролцсон. Энэ сургалтад нийслэлийн дүүргүүдийн эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийн хамт 2022 онд хамрагдсан. Сургалтаас цар тахлын үеийн эрчимт эмчилгээ, менежмент, зохиомол амьсгалуулалтын сүүлийн үеийн дэвшилтэт технологи арга, аргачлалуудыг мэдэж, өөрийн чадвараа нэмэгдүүлсэн. Өвчтөнүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээг

илүү чанартай болгох, стандартчлах, эмнэлзүйн шинэ заавар, хөтчүүдийг ашиглах боломж олгосон. КОВИД-19 -ийн ид дэгдэлтийн үеэр бид нэлээд ачаалалтай ажиллаж байлаа. Тухайн үед хүчилтөрөгчийн баллонуудаа Улаанбаатар хотод цэнэглэж, тээвэрлэж ирдэг байсан. Энэ оны 10 дугаар сард хүчилтөрөгчийн үйлдвэрээ ашиглалтад оруулсан. Одоо үйлдвэрээс ханын шугамаар хүчилтөрөгчөө авч, эрчимт эмчилгээний болон бусад тасгууд хүчилтөрөгчийн болон хийн хангамжын нэгдсэн системтэй болсон.



THE TRAINING “CRITICAL CARE AND ADVANCED MECHANICAL VENTILATION DURING PANDEMICS” WAS USEFUL

The training “Critical Care and Advanced Mechanical Ventilation during Pandemics”, which I attended together with one of our nurses, was very useful for us. This training was organized as part of the Save the Children’s healthcare project “Intensive Care Management of COVID-19, Advanced Technology and Methodology of Artificial Breathing” in 2022. Doctors and practitioners from the health facilities of Ulaanbaatar Municipality were also involved in the training.

For me and our nurse, the training was very useful in terms of acquiring skills to cope with the pandemic crisis by learning more about advanced modes of mechanical ventilation. It

was a significant contribution to my personal and professional development. It enabled us to improve the quality of health care, set standards and implement new guidelines and instructions in an updated form.

The pressure on our ICU increased from wave to wave during the pandemic. We had to refill our oxygen balloons from UB, 45 kilometers away, and transport them to our soum. Instead, a medical oxygen plant was implemented in Tuv province which allowed us to provide medical oxygen directly from a wall socket. The oxygen ecosystem now directly supplies our ICU as well as other departments of our hospital.

МЭДЛЭГ, ТУРШЛАГАА СУМУУДЫНХАА ЭМЧ НАРТАЙ ХУВААЛЦАЖ БАЙНА

Өнгөрсөн 6 дугаар сард 21 аймгийн нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээний эмч нарт зориулсан “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд КОВИД-19 халдварын эмнэлзүйг удирдахуй” сургалтад хамрагдаж, сургагч багш болон гэрчилгээ авсан. Энэ сургалтыг Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж байгаа “Монгол Улсад КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг сайжруулахад техникийн

туслалцаа үзүүлэх, зорилтод нийцүүлэн тархварзүйн хяналтыг дэмжих нь” төслийн хүрээнд зохион байгуулсан. Би эндээс суралцахын зэрэгцээ өөрийнхөө ажилд хэрэгтэй санаанууд олж авсан байгаа. Мөн суралцагчдыг сүүлийн үеийн олон улсад хэрэглэж байгаа сурах бичиг, гарын авлагаар хангасан нь их чухал байлаа. Эдгээрийг ашиглаад эмнэлэг доторхи журмаа боловсруулсан. Үүнд амьсгалын аппараттай ажиллах дүрэм ч бас багтсан.



Миний хувьд сум, орон нутгийн эмч нарт сургалт явуулна. Сумын эмч нар хүчилтөрөгчийн зөв хэрэглээний талаар мэдлэг бага. Тиймээс хүчилтөрөгчөөр хэрхэн хангах, өвчтөнөө хэрхэн үнэлэх, зөөвөрлөх, хүчилтөрөгчийн баллоноо бүрэн цэнэглэх, зөв тээвэрлэх талаас чиглүүлж, сургах нь чухал байдаг. Миний бодлоор аймгуудын нэгдсэн эмнэлгийн эмч нарыг сургагч багшаар бэлтгэсэн нь их зөв ажил болсон. Бид нар сургалт

явуулахын тулд олж авсан мэдлэгээ бататгана, сайжруулна, зарим зүйлээ дахиж судална. Сумдын эмч нар надтай уулзаж, эсвэл утсаар холбогдож, зөвлөгөө, сургалт авдаг. Тэдний хувьд анагаах ухааны их сургуулийн багш, эсвэл нийслэлийн лавлагаа шатлалын эмч нараас илүү аймгийнхаа эмч нараасаа авах нь хамтарч ажилладаг болохоор ажил мэргэжлийн шугамаар илүү их зөвлөгөө, мэдээлэл авах боломжтой юм шиг санагддаг.

SHARING THE NEW KNOWLEDGE AND SKILLS WITH OTHER DOCTORS AND PRACTITIONERS FROM OUR PROVINCE

I am now certified to facilitate training on “Clinical Management and Oxygen Therapy for COVID-19 cases at Primary Level Health Care Settings” after attending the training organized as part of the project “Technical Assistance to Strengthen the Covid-19 Response in Mongolia under Meeting Targets and Maintaining Epidemic Control (EpiC)”. This project has been implemented by Save the Children, funded by the United States Agency for International Development (USAID) and administered by FHI 360 (Family Health International) since January 2022.

The benefit I got from the training was not only limited to new professional skills; it also sparked ideas and insights that I can use in my work. Another important thing that I appreciated was the that participants were provided with handbooks used in international practice. Operational guidelines and instructions were developed as an integral part of our hospital’s internal bylaw. I developed the regulation for our hospital together with my colleagues, and the operating procedure for a mechanical

ventilator is attached to this internal bylaw.

I will provide further training to other soum doctors on the proper use of the oxygen cylinder, as they lack the skills and knowledge for oxygen therapy, triage of the patient, charging and safely transporting the oxygen cylinder.

In my opinion, training doctors from the aimag central hospitals was the right approach, enabling them to disseminate new knowledge and skills to soums. The trained doctors themselves need to reflect and improve on what they have acquired in order to effectively pass it on to others.

Doctors serving the soum communities get their advice and instruction from me in the form of telemedicine or face-to-face meetings. Doctors who work in soums mostly get advice and support from their central provincial hospitals rather than doctors or other practitioners at the university of medical science or capital city central hospitals.

МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭРЭЭ СУРГАЛТУУДАД ХАМРАГДДАГ

Миний хувьд мэргэжлийнхээ дагуу мэдээгүйжүүлгийн болон эрчимт эмчилгээний хоёр нийгэмлэгт харьяалагдаж, сургалтуудад нь хамрагддаг. Нийгэмлэгээс зохион байгуулдаг сургалт гэхэд жилдээ нэгээс хоёр удаа хоёр өдрөөр болдог. 2020 онд үндэсний сургагч багш нар аймгуудад ирж, КОВИД-ын үеийн эмнэлзүйн чиглэлээр эмч, сувилагч нарт 5 өдрийн сургалт явуулахад хамрагдсан. 2020-2021 онуудад цахим сургалтуудад хамрагдаж байсан. Манай аймгийн хувьд аймгийн Эрүүл мэндийн газраас сумдын эмч, сувилагч нарыг нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт тав хоног, төрөх тасагт тав хоног, мэс заслын тасагт 5 хоног гэх мэтээр дадлагажуулж, сургах ажлыг зохион байгуулдаг. Хуваарь гаргаад, нэг ээлжинд 2-3 сумын эмч нар ирдэг. Тэдний хувьд өөрсдөө ямар сургалтад хамрагдах хүсэлтээ бас гаргадаг юм. Би

2010 онд Азийн хөгжлийн банкны эрүүл мэндийн төслийн шугамаар аймгуудын эрчимт эмчилгээний эмч нарт “Амь тэнссэн үед үзүүлэх тусламж үйлчилгээ” сэдэвт 10 хоногийн сургалт явуулахад хамрагдаж, сургагч багш болж, өрх, сумдын эмч нарын амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээ үзүүлэх чадварыг сайжруулах чиглэлээр сургалт зохион байгуулж байсан.

Хүүхдийг Ивээх Сан АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр “Монгол Улсад КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг сайжруулахад техникийн туслалцаа үзүүлэх, зорилтод нийцүүлэн тархварзүйн хяналтыг дэмжих нь” төсөл хэрэгжүүлж, орон нутгийн нэгдсэн эмнэлгүүдийн эмч нарыг сургагч багшаар бэлтгэж, тэдний мэдлэг чадварыг нэмэгдүүлснээр бодит үр дүн гарч байгаа жишээний нэг нь энэ байлаа.

I ATTEND THE PROFESSIONAL TRAININGS

I have also participated in several advanced professional trainings. I attended workshops organized by the two anesthesiology and critical care associations to which I belong. These associations organize two 2-day workshops each year.

In 2020, national trainers conducted five-day clinical workshops at our soum during the pandemic period. As well, in 2020-2021, I participated in online workshops.

The Central Hospital of our province receives nurses and doctors from soums for five day

sessions in our intensive care unit. Depending on their interest and needs, we assign the visiting doctors and nurses to, for example, the departments of surgery, obstetrics and gynecology and anesthesiology. We can receive practitioners from 2-3 soums per session.

In addition, in 2010, I became a certified trainer in critical care rescue under a health project funded by the Asian Development Bank and organized a workshop for the doctors and nurses of other soums.

А.Жансерик:

ОНОЛ, ДАДЛАГА ХОСЛУУЛСАН ҮР ДҮНТЭЙ СУРГАЛТ БАЙЛАА



A. Janserik:

THE WORKSHOP WAS BOTH ACADEMICALLY AND PRACTICALLY EFFECTIVE

Саяхан зохион байгуулагдсан инженерүүдийг чадавхжуулах сургалтын талаар Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн инженер А.Жансерик ингэж хэллээ. Тэрээр 2022 оны 12 дугаар сарын 8-12-нд болсон “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдийг чадавхжуулах шаталсан сургалт”-д хамрагдсан инженерүүдийн нэг юм. Хүүхдийг Ивээх Сан АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр “Монгол Улсад КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг сайжруулахад техникийн туслалцаа үзүүлэх, зорилтод нийцүүлэн тархварзүйн хяналтыг дэмжих нь” төслийг 2022 оноос хэрэгжүүлж байгаа юм. Энэхүү төслийн хүрээнд уг сургалтыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар, Ассист Интернэшнл байгууллагатай хамтран явуулсан билээ.

A. Janserik, an engineer at the Central Hospital in Bayan-Ulgii Aimag, shared his experience with the Capacity Building of Engineers workshop. A. Janserik is one of the engineers who participated in a workshop on capacity building of engineers for medical equipment on December 8-12, 2022. This workshop was organized under the project “Technical Assistance to Strengthen the COVID-19 Response in Mongolia – “Meeting Targets and Maintaining Epidemic Control” implemented by Save the Children and funded by USAID in 2022. The workshop was co-hosted by Assist International, a medical equipment control and coordination institution.

Би ШУТИС-ийг эмнэлгийн тоног, төхөөрөмжийн инженер мэргэжлээр төгсөөд, Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлэгт 13 дахь жилдээ мэргэжлээрээ ажиллаж байна. Манай эмнэлэг хоёр инженер, гурван техникчтэй. Бид нэг алба болж, тоног төхөөрөмжөөс гадна хүчилтөрөгчийн үйлдвэрээ хариуцан ажилладаг. Нэгдсэн эмнэлэг 1000 гаруй тоног төхөөрөмжтэй тул ажлын ачаалал

нэлээд их. Уг нь 100 тоног төхөөрөмж тутам нэг инженер байх журамтай ч өнөөдөр манай эмнэлэг дээр нэг инженер 500 гаруй тоног төхөөрөмж хариуцан ажиллаж байна. Энэ удаагийн “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдийг чадавхжуулах шаталсан сургалт” онол, дадлага хослуулснаараа онцлогтой байлаа. Сургалт явуулсан Ассист Интернэшнл байгууллагын зөвлөхүүд

тоног төхөөрөмжийн эд ангийг засах, шалгах, тохируулах, жижиг эвдрэл гэмтлийг хэрхэн засах талаар нарийвчлан зааж, өөрсдийн туршлагаа хуваалцсан. Зөвлөхүүд мөн инженерүүдэд эмнэлгийн тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл үүсэхээс өмнө урьдчилан сэргийлэх үзлэг тогтмол хийх хэрэгтэй гэдгийг онцолж байлаа. Ийм сургалтууд инженерүүдэд их хэрэгтэй. Учир нь тоног төхөөрөмжүүд байнга шинэчлэгдэнэ, эмнэлгүүдэд шинээр ирнэ. Тиймээс инженерүүдийг аль болох олноор хамруулж байвал сайн. Миний хувьд өмнө нь эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдийн чадавх сайжруулах болон тоног төхөөрөмжийн программ хангамжийн сургалтад оролцсон. Мөн хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний гурав хоногийн сургалтад хамрагдаж байсан. Вакцины хөргөгч, хөлдөөгчийн хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх, хяналт тавих шаардлагатай байдаг учраас инженерүүдэд ийм сургалт явуулсан юм.

Мэдлэг, туршлагаа бусадтай хуваалцаж байна

Миний бодлоор цаашид инженерүүдийг лаборатори, дүрс оношилгоо, эрчимт эмчилгээний тоног төхөөрөмжийн чиглэл гэх мэтээр төрөлжүүлэн мэргэшүүлэн сургах шаардлагатай мэт санагддаг. Би өөрийн сурсан мэдсэнээ бусадтай хуваалцдаг. Хэдийгээр цалингийн хувьд

тийм хангалттай биш ч инженерийн чиглэлээр их, дээд сургууль төгссөн хүмүүс нутагтаа ажиллах хүсэлтэй байдаг. Гэхдээ төсөв мөнгөний хүрэлцээнээс болоод эмнэлэгт инженерийн орон тоо нэмдэггүй. Зарим аймагт Эрүүл мэндийн газартаа инженер, техникийн ажилтантай. Манай аймгийн хувьд байдаггүй. Тиймээс сумуудын эмнэлгээс эвдэрсэн, гэмтсэн тоног төхөөрөмжөө авчирч засуулах, заавар зөвлөгөө авах тохиолдол олон бий. Ирэх жил аймгийн Эрүүл мэндийн газар инженер авахаар төлөвлөж байгаа гэсэн. Манай эмнэлэг дээр инженерийн чиглэлээр сурч байгаа оюутнууд дадлага хийхээр ирнэ. Би тэдэнд өөрийн мэдлэг, туршлагаа байнга л хуваалцдаг. Эмч, сувилагч нар ажлын байрандаа тоног, төхөөрөмж ажиллуулж, харьцдаг. Тиймээс тэдэнд сургалт явуулж, заавар зөвлөгөө өгнө. Сургалтуудаас олж авсан мэдлэгээ ийм байдлаар бусадтайгаа хуваалцаж байна.

Багаж, хэрэгслийн багц чухал хэрэгцээтэй

Энэ удаагийн сургалтын хөтөлбөрт хэмжилтийн багажууд дээр хэрхэн ажиллах талаар багтсан. Хэрвээ ийм багажуудыг эмнэлгүүдэд өгвөл бид өөрсдийн засварласан багаж мөн шинээр ирж байгаа тоног төхөөрөмжийн хэвийн, зөв ажиллаж байгааг шалгах хэмжилтүүдээ хийгээд тоног, төхөөрөмжөө тохируулна.



Одоохондоо зарим эмнэлгүүдэд байхгүй байгаа ч цаашдаа хангагдаад явах байх хэмээн итгэж байна. “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдийг чадавхжуулах шаталсан сургалт”-ын дараа төгсөгчдөд гэрчилгээ, механик засвар, үйлчилгээнд өдөр тутам хэрэглэх багажийн багц өгсөнд инженерүүд их баяртай байгаа. Энэ багажаа ямар ч байсан

I graduated from the University of Science and Technology as a medical equipment engineer and have been working for Bayan-Ulgii Aimag Central Hospital for three years. There are 2 engineers and 3 technicians in our hospital. There are five of us working as a team and we are responsible for the operation of all equipment and oxygen production. Although the number of devices per engineer should be one hundred, our one engineer is now responsible for more than five hundred devices, as we have a total of 1,500. The uniqueness of this series of workshops was the quality of the teaching on theory and practice. The consultants from the co-organizer Assist International generously shared their experience in terms of inspection, minor damage repair and configuration setup. The consultants stressed the importance of checking equipment at regular intervals. Similar training or workshops need to be offered to medical equipment technicians, as this equipment is always on the cutting edge of technology and the types of equipment needed frequently change. Therefore, these types of workshops and coaching sessions need to reach as many engineers as possible. I have participated in several trainings, such as general training for engineers and programmers. I also participated in a 3-day workshop on refrigeration cycle maintenance since the temperature at which vaccines are required to be stored must be very accurate. I have started to share my new skills and experience with others.

I think future training and workshops need to be categorized, such as X-Ray equipment and critical care equipment, etc. I do my best to share everything I know with my colleagues, no matter what the purpose of the equipment is.

3-5 жилдээ хэрэглэх байх гэж бодож байна. Эмнэлгээс багажийн хангамж тийм ч сайн биш. Түгээмэл хэрэглэдэг цахилгаан хэмжигч багажийг гэхэд л заримдаа хувийнхаа зардлаар авах тохиолдол бий. Инженерүүд бүгдээрээ нэг өрөөнд суудаг болохоор багажаа дундаа хэрэглээд засвар, үйлчилгээгээ хийдэг.

Although graduates in medical engineering do not earn very much in provincial areas, they do want to return home if they can be employed there. Because of budgetary constraints, few new engineer positions are being created. Some aimags have engineers and technicians in their local health facilities, but in Bayan-Ulgii, there is no such unit in the health center, and therefore we at the Central Hospital are responsible for repairing all the medical equipment.

We also receive and repair the medical equipment from the soums and provide consultation to the soum hospitals. I have heard that the Aimag health center is planning to hire an engineer next year.

I supervise the interns in our hospital. I also train, supervise, and advise our doctors and nurses, as they are the end users of all this equipment. A set of tools is essential. Therefore, in this series of capacity building workshops, we learned how to use multimedia tools. When we are equipped with such essential tools, we can optimize the old tools and adjust the settings of the devices properly. So far, not all hospitals have such equipment but we hope it will be made available in the near future. The engineers who participated in the capacity building workshop series for medical equipment engineers were very satisfied with the set of tools. They're mechanical and for daily use and will be useful because the provision of tools by the hospital is not good and often we even have to buy the most basic tools. We are sure that we'll be able to use these tools for 3 to 5 years and can share them because we work in one room. We were also given certificates from this workshop series.

Г.Навчаа:

ШААРДЛАГАТАЙ ҮЕД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖӨӨР ТУСАЛЖ, АШИГЛАХ СУРГАЛТ ЯВУУЛСАН НЬ ЦАГАА ОЛСОН ДЭМЖЛЭГ БАЙЛАА

G. Navchaa:

THIS TRAINING AND PROVISION OF TOOLS CAME AT JUST THE RIGHT TIME

Хүүхдийг Ивээх Сан АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр “Монгол Улсад КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг сайжруулахад техникийн туслалцаа үзүүлэх, зорилтод нийцүүлэн тархварзүйн хяналтыг дэмжих нь” төслийг Эрүүл мэндийн яамтай хамтран хэрэгжүүлж байна. Төслийн үр дүнгийн талаар Эрүүл мэндийн яамны Анхан болон лавлагаа шатлалын тусламжийн хэлтсийн дарга Г.Навчаатай ярилцлаа.

Save the Children is implementing the USAID-funded project “Technical Assistance to Strengthen the COVID-19 Response in Mongolia” in collaboration with the Ministry of Health. We interviewed G.Navchaa, the head of the Primary and Referral Level Health Service Division of the Ministry of Health about the project outcomes.

- Төслийн хүрээнд эмнэлгүүдэд амьсгалын аппарат, хүчилтөрөгчийн баллон, дагалдах хэрэгсэл зэрэг тоног төхөөрөмжүүд нийлүүлсэн. Эмнэлгүүдэд тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлага хэр байсан бэ?

- Монгол Улсын эрүүл мэндийн салбарт шаардлагатай олон тоног төхөөрөмжийн хангалт үе шаттайгаар хийгдэж байдаг ч амьсгалын аппаратын хэрэгцээ байсаар байсан. Энэ дутагдал хэвийн үед илт мэдэгдэхүйц асуудал үүсэхээр хэмжээнд бол байгаагүй. Гэтэл КОВИД-19-ийн үеэр амьсгалын дутагдалтай өвчтөний тоо богино хугацаанд хэт олноор нэмэгдэж, аппаратын тоо хүрэлцэхгүй болж эхэлсэн. Яг л ийм хэрэгцээ шаардлагатай тулгамдсан үед төслийн зүгээс тоног төхөөрөмжөөр дэмжлэг үзүүлж,

зэрэгцүүлэн эмч, сувилагч, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдэд аппаратын ашиглалтын талаар сургалт явуулсан нь цагаа олсон дэмжлэг байлаа. Зөвхөн амьсгалын аппарат биш хүчилтөрөгчийн үйлдвэрийг аймгийн төвүүдэд байгуулсан нь чухал ажил болсон. Хэдийгээр Эрүүл мэндийн яамнаас ийм үйлдвэрүүдийг ээлж дараагаар байгуулж байсан ч бүх аймгуудыг ижил түвшинд хүргэнэ гэдэг цар тахалтай тэмцэж байсан тухайн цаг үед амаргүй байх байсан ч төслийн дэмжлэгээр бид тэр түвшинд хүргэж чадсан. Төслийн нэг давуу тал нь алсыг харж, цаашдын тогтвортой, найдвартай тогтолцоог бүрдүүлэхэд анхааран, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, засвар үйлчилгээг цогцоор нь шийдсэнийг их талархан хүлээж авч байгаа. КОВИД-19 болон томуу, томуу



төст болон бусад өвчлөлийн дэгдэлтийн үед ашиглах тоног төхөөрөмжийн бэлэн байдал боломжийн хэмжээнд хангагдсан. Энэ тал дээр эмнэлгийн мэргэжилтнүүд ч сайн бэлтгэгдсэн. Аливаа аппарат тоног төхөөрөмж элэгдэн хуучирч, засах сэлбэх, шинэчлэгдэн сайжруулах хэрэгцээ байх хэдий ч бэлтгэгдсэн мэргэжилтнүүд эдгээр олгогдсон тоног төхөөрөмжийг зөв ашиглан, илүү урт хугацаанд хэрэглэнэ гэдэгт найдаж байна.

- Төслийн хүрээнд олон сургалтууд зохион байгуулсан. Тухайлбал, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдийн сургалт яагаад хэрэгцээтэй байдаг вэ?

- Багаар сургах нь их чухал. Тухайлбал эмч нарыг сувилагч, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженертэй нь хамт. Өмнө нь эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдийг бүсчилсэн байдлаар сургаж байсан л даа. Гэхдээ энэ удаа 21 аймаг, 9 дүүргийнхийг бүгдийг хамруулан, улсын хэмжээнд нэг түвшинд зэрэг сургаж байгаа нь давуу талтай. Манай улсад хүний нөөцийн тогтворгүй байдал олон салбарт ажиглагдаж байгаа нь эрүүл мэндийн салбарт ч адил байна. Сургалтад оролцсон хүмүүс ажлаас гарах, солигдох тохиолдлууд бий. Тиймээс сургалтаа давтах, сайжруулах, шинэ ирсэн хүмүүсээ

Respiratory support devices, oxygen cylinders, tools and supplies were distributed to several hospitals. What was the need for equipment at hospitals?

The health sector is regularly supplied with essential equipment. Nevertheless, we had a shortage of respiratory support equipment. Prior to the proliferation of COVID-19, there was no shortage of respiratory support devices. Due to the strong wave of COVID-19, we received an enormous number of patients who had respiratory failure and we realized we couldn't really provide enough oxygen to treat critical care patients. Right at that time, we were provided with essential equipment by the project. In addition, our doctors, nurses and biomedical engineers were trained and advised on how to operate, maintain, check and repair the equipment. An oxygen ecosystem was also set up for direct supply to wall outlets in aimag central hospitals.

Although the government provided similar medical oxygen plant, it was not possible for government to meet the needs of all hospitals at the same level in such a short time. With the support of this project, we were able to achieve equitable levels of oxygen supply. The project was also far-sighted as it has left a long-lasting impact. It laid the foundation for a sustainable and reliable mechanism in the health sector, contributing safe equipment as well as coaching in maintenance and service.

We are now prepared, both in terms of equipment and personnel, for an emergency situation such as COVID-19, flu-like and flu symptoms. Our doctors, nurses and engineers are well-trained and educated to use, maintain and repair the equipment, so we will be able to put it to good use into the future.

Several other trainings have been organized as part of this project. Why is training necessary for biomedical engineers?

Teamwork is very beneficial. Previously, engineers were trained separately by region. But in this case, the doctors, nurses and engineers from all provinces were able to learn from each other and master the same level of content and competence.



сургах зэргээр тасралтгүй явуулах шаардлага бий. Цаашид ч энэ талын сургагдсан хүний нөөцийн тэнцвэртэй байдлыг нь алдагдуулахгүй байх тал дээр Эрүүл мэндийн яамнаас анхаарах бодлого барин ажиллаж байна.

- **Аймаг, дүүргийн эмнэлгүүдийн эрчимт эмчилгээний эмч нарыг сургагч багшаар бэлдсэн. Мөн анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд КОВИД-19 халдварын тохиолдлуудын эмнэлзүйн тусламж үйлчилгээг удирдах сургалтад бүх сумын эмч, сувилагч нарыг хамруулаа. Эдгээр сургалтын үр дүнгийн талаар ярина уу?**

- Гаднаас өндөр мэргэшсэн зөвлөх ирээд сургалт явуулахын зэрэгцээ үндэсний сургагч багш нартай болно гэдэг сайн хэрэг. Сургагч багш нарын хувьд тухайн газартаа ажилладаг учраас давуу болон сул талаа сайн мэдэж байдаг ба зөвлөхүүдээс сурсан зүйлээ өөрийнхөө туршлагатай хамт бусдад дамжуулдгаараа давуу талтай. Эрүүл мэндийн яамнаас сургагч багш нарын тоог байнга нэмэгдүүлэх бодлого баримталдаг. Өөрөөр хэлбэл өмнө хэлсэнчлэн хүний нөөцийн тогтворгүй

байдлаас шалтгаалаад сургагч багш нарыг аль болох олон түвшинд тасралтгүй бэлтгэх шаардлага гардаг. Хүмүүс томоохон эмнэлгүүдэд сургагч багш байдаг гэж ойлгодог. Сумын эмнэлэгт ч сургагч багш байж болно.

- **Эрүүл мэндийн яамны зөвлөмжөөр 330 суманд 800 хүчилтөрөгчийн баллон, дагалдах хэрэгслийг төслөөс хандивласан. Та бүхэн эдгээр сумуудыг хэрхэн, ямар байдлаар сонгосон бэ?**

- Хэрэгцээт газар нь зөв хуваарилах нь чухал хэрэг. Бид тоног төхөөрөмжийн хуваарилалтыг хийхдээ хэрэгцээ шаардлагад тулгуурласан, хангалтыг судалсан тоо баримтад тулгаруулан тооцдог. Тухайлбал, бид аймгуудын Эрүүл мэндийн газартай холбогдоод 330 суманд хүчилтөрөгчийн баллон байгаа эсэх, хэд байгаа талаар мэдээлэл авсан бөгөөд тодорхой сумдыг сонгон, утсаар ярьж нөхцөл байдлыг баталгаажуулсан. Хүн амынх нь тоогоор А, Б, В зэрэглэлийн сум эрүүл мэндийн төв гэж ангилдаг ба А зэрэглэл нь яаралтай тусламж үзүүлдэг, хагалгаа хийдэг газруудад арай олон тоотой хуваарилсан. Нэг суманд

4 баллоныг 2 нь суурин, 2 нь авч яваад цэнэглэж, солих байдлаар ашиглана гэж тооцоолсон. Манай улсын эрүүл мэндийн тогтолцооны давуу тал бол Эрүүл мэндийн яам, лавлагаа төвүүд, аймгийн Эрүүл мэндийн газрууд, аймгийн нэгдсэн эмнэлэг, тэгээд анхан шатны сум өрхийн эмнэлгүүд гээд орон даяар нэгдсэн тогтолцоотой. Энэ тогтолцооны давуу тал нь мэдээллийг анхдагч эх сурвалжаас нь бүрэн авах боломжтой байдаг ба эргэн

ашиглалт хэрэглээг тооцохдоо мөн л энэ шат дарааллаар эргэн хянаж дэмжин ажилладаг. Бидний хамтран хуваарилсан хүчилтөрөгчийн зөөврийн баллонууд хуваарилагдсан нэгж сумын эмнэлгүүд рүү хүргэгдэж эхлэхээр энэ цаг үед замдаа гарч, түрүүчээсээ зорьсон цэгт хүлээн авч аль хэдийн тусламж үйлчилгээнд ашиглагдаж эхэлснийг дуулгахад таатай байна.

Ярилцлага өгсөнд баярлалаа.

Our country is not sustainable in terms of its human resources. There is a high turnover in all industries, including health care. There is no assurance that the people who participated in this workshop will not leave their jobs, although the ministry is introducing procedural regulations to reduce the rate of turnover. So it's important that the skills acquired by senior participants be updated and passed on to newly hired younger participants.

Intensive care doctors from provinces and districts were trained as trainers under the project. Additionally, all nurses and doctors from all soums have been trained to handle the clinical triage of the pandemic and provide rapid first aid. We would like to ask you to share with us how effective these trainings have been.

Attending training organized by foreign experts that develops national trainers is a real advantage for us. National trainers are key as they know the weaknesses and strengths of their communities and are able to put into practice and localize the skills learned from the experts. The Ministry of Health prefers to prepare national trainers on an ongoing basis at all levels because of the high turnover that I mentioned earlier.

Traditionally, it was thought that a trainer or expert from the central hospitals should train others. However, soums also benefit from having their own trainers.

As recommended by the Ministry of Health, 800 oxygen cylinders and related supplies were donated to 330 soum hospitals. Can you please explain more about the process by which you or the Ministry selected these soum hospitals?

Sure. The donations were to go to the places with the highest need. We based this on the supply data that came out of our needs assessment. We checked with the central hospitals in all provinces to find out whether all 330 soum hospitals had oxygen cylinders. We then checked the situation by phone with several soum hospitals. Soums are classified into A, B and C by population. We allocated more oxygen cylinders and supplies to category A because soum hospitals in category A perform surgeries and first aid. Each soum was assigned four cylinders, with 2 cylinders to be used as the main oxygen source and the remaining 2 for mobile service. A major advantage of our health system is its centralized structure, i.e., the Ministry of Health, the referring centers, the health divisions and central hospitals of provinces and the primary healthcare facilities of soums all work closely together. This centralized mechanism enables us to collect information at the primary level of health care to promote the work. It is my pleasure to confirm that the cylinders and attachments are on their way to the targets we selected together and some targets have already received and used the cylinders.

Thank you for talking with us.

Ж.Сэргэлэн:

АНХАН ШАТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖҮҮДЭЭР ХАНГАХ НЬ НЭН ЧУХАЛ



Dr. J.Sergelen:

IT IS CRUCIAL TO PROVIDE PRIMARY HEALTHCARE FACILITIES WITH ESSENTIAL EQUIPMENT

Хүүхдийг Ивээх Сангаас хэрэгжүүлж буй “Монгол Улсад КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг сайжруулахад техникийн туслалцаа үзүүлэх, зорилтод нийцүүлэн тархварзүйн хяналтыг дэмжих нь” төслийн хүрээнд 330 сумын 660 эмнэлгийн ажилтнуудын чадавхыг сайжруулж, Монгол орон даяар гурван үе шаттай цогц сургалтууд зохион байгуулж байгаа билээ. Сургалтад оролцсон эмч нарын төлөөлөл болох Булган аймгийн Бугат сумын эрүүл мэндийн төвийн дарга, хүний их эмч Ж.Сэргэлэнтэй ярилцлаа. Тэрээр 1986 онд Анагаах ухааны дээд сургууль төгсөж, ажлын гараагаа Булган аймгийн Сэлэнгэ сумаас эхэлж, хөдөө орон нутгийн эрүүл мэндийн салбарт 36 дахь жилдээ ажиллаж байна.

Over 660 health practitioners from 330 soums took part in the comprehensive, three-staged capacity building training organized throughout the country as part of the project “Technical Assistance to Strengthen the COVID-19 Response in Mongolia - Meeting Targets and Maintaining Epidemic Control” (EpiC). We interviewed Dr. J.Sergelen, the head of Bugat soum’s Healthcare Facility in the province of Bulgan and a representative of the participating physicians. She graduated from the University of Medical Sciences in 1986 and began her career in Bulgan province where she has spent 36 years working in the rural health sector.

- Та сургалтын үр дүнгийн талаар бодлоо хуваалцана уу?

- Би Эрдэнэт хотод 2022 оны 8 дугаар сарын 8-10-нд зохион байгуулагдсан “Анхан шатны эрүүл мэндийн тогтолцоонд КОВИД-19 халдварын тохиолдлуудын эмнэлзүйн тусламж үйлчилгээг удирдахуй, хүчилтөрөгч эмчилгээ” сургалтад хамрагдлаа. Булган аймгийн 16 сумаас нийт 32 эмч, сувилагч нар ирж, маш хэрэгцээтэй мэдлэг мэдээлэл авч, чадвараа сайжрууллаа. КОВИД-19 цар тахлын тархалт ихсэж байгаа энэ цаг үед онол, дадлага хослуулж, эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн нарийн мэргэжлийн эмч нар хамтарч сургалт явуулж байгаа нь өндөр ач холбогдолтой байлаа. Хоёр жилийн өмнө энэ сургалтад хамрагдсан бол үр дүн их гарах байж хэмээн бодогдож байгааг нуух юун. Сургалт агуулгаар баялаг, хэрэгцээнд суурилсан нь чухал. Тухайлбал, хүчилтөрөгчийн баллоныг ажиллуулах бол чадвар шаардсан ажил. Эмнэлгийн бүх ажилтнууд мэдэх шаардлагатай. Бид өөрсдөө сураад, орон нутагтаа сургагч багш болсноор бусад эмч мэргэжилтнүүддээ зааж өгөх боломж нээгдэж байгаагаараа давуу талтай. Өөрөөр хэлбэл цаг үеэ олсон маш сайн сургалт гэж дүгнэж байна. Энэ нь цаашид зөвхөн КОВИД-19 биш, бусад халдварт өвчин төдийгүй яаралтай тусламжийн үед ч хэрэгжүүлэхэд ач холбогдолтой юм.

- Танай эмнэлгийнхэн КОВИД-19 цар тахлыг даван туулахад ямар бэрхшээлүүдтэй тулгарч байсан бэ?

- Хүндрэлүүд их гарсан. Чадлынхаа хэрээр бэлэн байдлаа хангасан ч хүний нөөц, тоног төхөөрөмж дутагдалтай байна. Нийт 262 тохиолдлоос 140 нь эмнэлэгт хэвтэж бусад нь гэрээр эмчлэгдсэн. Хэвтэн эмчлүүлсэн 140 хүнээс 10 гаруй нь хүнд буюу хүндэвтэр байсан. Өнгөрсөн хугацаанд хүчилтөрөгчийн хангамж, тоног

төхөөрөмж маш их дутагдсан. Байгаа нөөц бололцооныхоо хэмжээнд анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлээд, шаардлагатай тохиолдолд өвчтөнүүдээ аймгийн төвлөрсөн эмнэлгүүдэд үргэлжлүүлэн эмчлүүлсний үр дүнд нас баралт гараагүй. Нөгөө талаас тандалтын ажиллагааг манай суманд маш сайн хийж байсан нь давуу тал болсон. Одоо КОВИД-19-ийн 5 дахь давлагаа эхэлж байна. Томуу, томуу төст өвчинтэй ижил шинж тэмдгээр илэрч байгаа нь улам төвөгтэй болгож байна. Тоног төхөөрөмжийн хувьд нэн шаардлагатай нь хүчилтөрөгчийн баллон байна. Бид хүчилтөрөгчийн өтгөрүүлэгчээр амьсгалын дутагдалд орсон хүмүүст эмчилгээ хийхэд үр дүн гараагүй. Зуун хувийн хүчилтөрөгчтэй баллоноор эмчилгээ хийхэд ямар үр дүнтэй байсныг өнгөрсөн хоёр жилийн хугацаанд мэдсэн учраас бид 2-3 баллон өөрсдийн боломжоор авсан. Гэхдээ дагалдах хэрэгсэл, тухайлбал даралт тогтворжуулагч нь дутуу, суурилуулж чадахгүй зэрэг бэрхшээлүүд бий. Цар тахал цаашид хэрхэн тархахыг бид хэлж мэдэхгүй. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас өвчтөн хүндрэх үү, нас барах уу гэдэг нь шийдэгдэх тул шаардлагатай тоног төхөөрөмжүүдээр хангах нь нэн чухал.

- КОВИД-19 туссан хүнд өвчтөнүүдээ дараагийн шатлалын эмнэлэг рүү тээвэрлэх явцад ямар хүндрэлүүд гарч байсан бэ?

- Манай сумын хувьд 10 гаруй тохиолдол хүнд болон хүндэвтэр байсан. Үүнээс нэг тохиолдол маш хүндрэлтэй байсан тул зөөвөрлөсөн, бусад өвчтөнүүдийг сумандаа эмчилсэн. Тээвэрлэхэд бэрхшээл их. Өөрсдөө халдвар авах эрсдэл өндрөөс гадна тээврийн хэрэгсэлд хүчилтөрөгч зайлшгүй байрлуулах шаардлагатай. Хүчилтөрөгч өтгөрүүлэгчийг машинд

залган авч явах боломжгүй, тухайн үед хүчилтөрөгчийн баллон байхгүй байсан учраас өвчтөнөө улам дордуулах эрсдэлтэй байсан. Аймгаас хүнд хүмүүсийг хүчилтөрөгчгүйгээр зөөхгүй гэсэн чиглэл өгсөн тул аль болох сум орон нутагтаа зохицуулалт хийж ирсэн.

- Танай орон нутаг болон эмнэлгийн онцлог юу вэ?

- Бугат сум бол уулархаг, өндөрлөг газар. Засаг захиргааны гурван нэгжтэй, 2300 гаруй хүн амтай. Нутгийн алслагдсан баг сумын төвөөсөө 200 километр байрладаг. Зам бартаа ихтэй, даваа гүвээ олонтой. Тиймээс өвчтөнүүддээ хүрч үйлчлэхэд хүндрэлтэй. Манай сумын эмнэлэг 1954 онд байгуулагдсан. Нэг их эмч, хоёр бага эмч, нэг эх баригч, таван сувилагч, үйлчилгээний ажилтнууд гээд нийт

18 хүний орон тоотой ажиллаж байна. Батлагдсан орон тоо 21 боловч сүүлийн гурван жилд эмч, сувилагчдын хомсдолд ороод байна. Хөдөө орон нутагт эмч нар их ирэхгүй, сувилагч нар бас дутагдалтай. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж ихээхэн буурсан. Хөдөөгийн эмч нар их хүнд нөхцөлд ажилладаг хүмүүс. Цаг агаарын хүнд нөхцөлтэй, тусламж үйлчилгээ үзүүлэхэд үргэлж очиж үйлчлэх шаардлагатай. Эмч нар өөрсдөө судалгаагаа хийнэ, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлнэ, удирдах, зохион байгуулалтын ажлаа хийх зэрэг нэг хүн хэт их ачаалалтай ажилладаг. Мөн ард иргэд тусламж үйлчилгээг цаг хугацаанд нь авахгүй байгаад гомдол гаргадаг. Тиймээс хүний нөөцийн бодлогоо сайжруулах шаардлагатай. Ярилцсанд баярлалаа.



- Would you like to share your thoughts on the training outcomes?

- On August 8-10, 2022, I attended training on “Clinical care management and oxygen therapy in the primary healthcare system for cases of COVID-19 infection” in Erdenet city. A total of 32 doctors and nurses from 16 soums of the province of Bulgan gathered to improve their knowledge and abilities. During the escalating spread of the COVID-19 pandemic, it was particularly important for intensive care and emergency medical specialists to receive comprehensive training that integrated theory and practice. I thought ‘if only this training had been conducted two years ago’.

Needs-based training, rich in content was required. For instance, operating an oxygen cylinder needs skill. All hospital personnel must be well informed. We have the advantage of learning independently and becoming trainers in our community, which allows us to instruct other medical professionals. In other words, the training was timely and provided an excellent course that will prove useful not only for newly emerging and reemerging infectious diseases, but also in emergencies.

- What challenges did your hospital face in its fight against the COVID-19 pandemic?

- There were numerous difficulties. Although we were as well-prepared as possible, we needed more personnel and equipment. Out of 262 infected cases, 140 cases were hospitalized, while the remaining cases were treated at home. More than 10 of the 140 hospitalized patients were severe or very severe. We had a serious lack of oxygen supplies and equipment in the past. Fortunately, as a result of the prompt provision of primary care to the extent of our available resources as well as ongoing treatment of patients in central and provincial hospitals when necessary, there were no deaths. On the other hand, the surveillance in our soum

was excellent. Now the fifth COVID-19 wave has commenced, and the fact that patients exhibit the same symptoms as influenza and flu-like illnesses complicates matters. Oxygen cylinders are essential equipment. We had no success using oxygen concentrators to treat patients with respiratory failure. Over the past two years the efficacy of 100% oxygen cylinder therapy has been demonstrated, and we have now acquired two to three cylinders. However, we weren’t able to install the accompanying blood pressure stabilizers. We can’t predict how the pandemic will spread, but as primary healthcare facilities will decide whether a patient’s condition will become worse or die, it is crucial that the necessary equipment is on hand.

- What challenges did you encounter while transporting COVID-19-infected patients to advanced hospitals?

- More than ten of our patients were severe or worse. One patient’s condition was so complex that the person had to be transferred, while the remaining patients were treated in our local healthcare facility. There are a number of challenges with transporting patients. In addition to the high risk of having our health practitioners being infected, oxygen must be available inside the vehicle, but as it’s impossible to plug in an oxygen concentrator to a car and no oxygen cylinders were available, there was a risk that the patient’s condition would worsen. As the province has instructed against transporting heavy individuals without oxygen, and local arrangements are being prioritized.

- How would you specify the peculiarities of your community and healthcare facility?

- Bugat soum is geographically elevated. It has three administrative units and a population over 2,300. The local team works remotely, as far as 200 kilometers from the soum’s center. The road is extremely rough and

bumpy, making it challenging to commute to the patients. Our soum healthcare facility was established in 1954. It employs 18 individuals, including one senior physician, two junior physicians, one midwife, five nurses, and service staff. Physicians and nurses are scarce in rural areas, and although we have 21 vacancies approved, we have been short of physicians and nurses for the last three years and access to medical care is drastically diminished. Rural physicians work under often overwhelming conditions. Emergency

services are always in demand in extreme weather, and in addition, the workload is compounded by doctors themselves having to conduct research, provide medical care, and manage and organize their work because only one doctor is on hand. People also complain about the slow delivery of care. Consequently, it is essential that policies associated with developing and maintaining human resources are improved.

Thank you for the conversation.



АМЬСГАЛЫН АППАРАТНЫ ТУСЛАМЖТАЙГААР 100 ГАРУЙ ХҮНИЙ АМЬ НАС АВАРЧЭЭ

WITH THE HELP OF VENTILATORS, MORE THAN 100 LIVES SAVED



АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагаар дамжуулан Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсын КОВИД-19 цар тахлын эсрэг хийж буй хүчин чармайлтыг дэмжих зорилгоор 2020 оны сүүлчээр амьсгалын 50 аппарат хандивлаж, тэдгээрийг Архангай, Баянхонгор, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Өвөрхангай, Говьсүмбэр, Хэнтий, Сэлэнгэ, Орхон, Завхан гэсэн 11 аймагт хуваарилсан юм. Үүний дараа эмч, сувилагч нарт тоног төхөөрөмжөө хэвийн ажиллуулахад шаардлагатай сургалт явуулжээ. Эдгээр аймгуудын нэг болох Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийнхөн сургалтанд хамрагдаж, амьсгалын аппаратаа хэрхэн ашиглаж байгаа, ямар үр дүнгүүд гарсан талаар танилцуулж байна.

The United States donated 50 ventilators to Mongolia that were distributed to 11 aimags through the United States Agency for International Development (USAID): Arkhangai, Bayankhongor, Darkhan-Uul, Dornod, Dornogovi, Uvurkhangai, Govisumber, Khentii, Selenge, Orkhon and Zavkhan. Subsequently, doctors and nurses were trained in the proper use of the ventilators. Doctors and nurses at the Regional Diagnostic and Treatment Center in Dornod aimag, one of the provinces to receive the ventilators, undertook the training which also included presentation of treatment results.

ЗҮҮН БҮСИЙН ЭМЧИЛГЭЭ ОНОШИЛГООНЫ ТӨВ

Монгол орны зүүн бүсийн хамгийн том аймаг бол Дорнод юм. Тус аймгийн төв Улаанбаатар хотоос 636 км зайтай орших бөгөөд нийслэл хоттой засмал замаар холбогддог. Нийт 85 мянган хүн амтай. Дорнод аймгийн Чойбалсан хотод Зүүн Бүсийн оношилгоо эмчилгээний төв байрладаг. Энэ төв байгуулагдаад 95 жил болж байгаа бөгөөд Дорнод, Сүхбаатар аймгийн төв, тэдгээрийн бүх сум, Хэнтий аймгийн Дадал, Баян-Овоо, Батноров, Норовлин, Бэрх, Баян-Адарга сумдын газар нутагт оршин суух 140 мянга гаруй хүн амд үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн, яаралтай тусламж үзүүлэх, бүс нутгийн эмнэлгүүдийн эмч мэргэжилтнүүдийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, анагаах ухааны судалгаа шинжилгээний ажил эрхлэх үүрэгтэй ажилладаг. Өнөөдөр 8 алба, 22 тасаг, 500 ажилтан, 104 эмчтэй, 336 ортой үйл ажиллагаа явуулж байгаа аж.

THE EASTERN REGIONAL MEDICAL DIAGNOSTIC CENTER

Dornod is the largest aimag in the eastern region of Mongolia with a population of 85,000. The aimag center is located 636 km away from Ulaanbaatar and is connected to the capital city by paved roads. The Eastern Regional Diagnostic and Treatment Center, located in Choibalsan, Dornod aimag, was established 95 years ago. The Center is responsible for providing basic and specialized regular and emergency health services for more than 140,000 people living in Dornod and Sukhbaatar aimag centers, as well as all their soums, including Dadal, Bayan-Ovoo, Batnorov, Norovlin, Berkh and Bayan-Adarga soums of Khentii aimag. It is also responsible for improving the knowledge and skills of doctors in regional hospitals, providing them with professional and methodological advice, and conducting medical research. Today, the center has 8 clinics, 22 departments, 500 staff, and 104 doctors, and the capacity to receive 336 patients at a time.



Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Сургалт, судалгаа, хамтын ажиллагааны албаны дарга Х.Ууганцэцэг

Kh.Uugantsetseg, Head of Training, Research and Cooperation Department, Dornod Aimag Regional Diagnostic and Treatment Center

“

Манай төв өнгөрсөн 2021 он амбулаториор 131615 өвчтөн, 12552 өвчтөнг хэвтүүлэн эмчилж, 7569 өвчтөнд дуудлагаар түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлж, 2201 хүнд мэс засал хийж, 1584 эмэгтэйд төрөх тойрны тусламж үзүүлээ.

”

“

Our center treats over 130,000 patients in outpatient clinics and 12,500 patients in medical clinics, provides emergency services to over 7,500 patients, operates on 2,200 patients, and provides maternal assistance and services to 1,500 pregnant women annually.

”

АППАРАТНЫ ТУСЛАМЖААР ОЛОН ХҮНИЙ АМЬ НАС АВАРЧЭЭ

Дорнод аймагт 2021 оны 4 дүгээр сард КОВИД-19-ийн анхны тохиолдол илэрсэн байна. Үүний дараа Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийнхөн тусламжийн таван ширхэг амьсгалын аппарат хүлээн авчээ. Герман улсад үйлдвэрлэсэн энэхүү төхөөрөмж нь найдвартай үйл ажиллагаатай, зөөвөрлөхөд хөнгөн, бат бөх, овор багатай, эмнэлгийн нөхцөлд хүн тээвэрлэхэд ашиглах боломжтой, хөдөлгөөнтэй үед эрчим хүч нэмэлтээр шаардахгүй зэрэг олон давуу талтай юм. Тус төвийн хоёр инженер АНУ-ын нийлүүлэгч талын холбогдох хүмүүстэй цахимаар холбогдон зөвлөгөө авч, амьсгалын аппаратаа тохируулж, хэвийн ажиллагаанд оруулжээ. Дорнод аймагт цар тахлын давалгаа эрчимжсэн үе буюу 2021 оны 10 дугаар сарын 2-4-нд “Монгол Улсад КОВИД-19-ийн хариу арга хэмжээг сайжруулахад техникийн туслалцаа үзүүлэх, зорилтод нийцүүлэн тархварзүйн хяналтыг дэмжих” (EpiC) төслийн хүрээнд “Цар тахлын үеийн эрчимт эмчилгээ, зохиомол амьсгалуулалтын

дэвшилтэт технологи арга, аргачлал” сургалтыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвд зохион байгуулж, амьсгалын шинэ аппаратаар өвчтөнг хэрхэн удирдах зэрэг мэдлэг, чадварууд олгосон байна. Энэхүү сургалтад Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр зэрэг зүүн бүсийн дөрвөн аймгийн эмч, сувилагч нар хамрагджээ.

Амьсгалын аппаратны сургалт нь бодит төхөөрөмж дээр тайлбарлах, туршилт хийх байдлаар онол, дадлага хослуулсан хэлбэрээр явагджээ. “Vyaire Medical” үйлдвэрийн амьсгалын аппаратны LTV2 2200 загвар нь эмч, сувилагчид хэрэглэхэд хялбар байдгаараа онцлогтой.

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагаар дамжуулан Америкийн Нэгдсэн Улсаас Монголд хандивласан амьсгалын 50 аппарат нь цаг үеэ олсон, нэн хэрэгцээтэй, олон хүний амь нас аврах боломжтой тоног төхөөрөмж байсан нь Дорнод аймаг дахь жишээнээс харж болно.



Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Мэдээгүйжүүлэлт, эрчим эмчилгээний тасгийн эрхлэгч, их эмч С.Дэлгэржаргал

Dr. S. Delgerjargal, Head of the Department of Anesthesia and Intensive Care, Dornod Regional Diagnostic and Treatment Center

“

Бид сургалтын үр дүнд амьсгалын аппаратаа бүрэн ашиглаж сурсан. Ковид-19 цар тахлын үед эдгээр амьсгалын аппаратын тусламжтайгаар 100 гаруй хүний амь насыг аварсан. Үүнээс гадна нэн хүнд, ухаангүй өвчтөнд энэхүү аппаратаар дамжуулан зохиомол амьсгал хийж, Дорнод аймгаас Улаанбаатар хот хүртэл 600 гаруй км тээвэрлэж хүргэсэн.

”

“

As a result of the training, we learnt how to use our ventilators, and with the help of these ventilators, more than 100 lives were saved during the Covid-19 pandemic. Moreover, the device provided artificial respiration to critically ill and unconscious patients being transported to Ulaanbaatar, more than 600 km away from Dornod aimag.

”

WITH THE HELP OF VENTILATORS, MANY LIVES SAVED



The first case of Covid-19 was confirmed in April 2021 in Dornod aimag, after which the Dornod Regional Diagnostic and Treatment Center received five donated ventilators. This German-produced device had many advantages, in particular it was compact, lightweight, durable and reliable. It could be also used to transport patients without requiring additional power. The center's two engineering staff contacted the US suppliers online for advice and adjusted the ventilators to make them locally operational. During the pandemic, training was organized at the center in Dornod on October 2-4, 2021, within the framework of the "Meeting Targets and Maintaining Epidemic Control (EpiC)" project. Doctors and nurses from provincial hospitals of the four eastern aimags, including Dornod, Khentii, Sukhbaatar and Govisumber attended the "Training of Trainers (ToT) course on Emergency Critical Care and COVID-19 Adult Case Management".

Training on the use of ventilators was a combination of theory and practice, providing comprehensive explanations and practical use of the devices. The LTV2 2200 ventilator provided by Vyair Medical proved to be user-friendly for doctors and nurses.

This example from Dornod Aimag demonstrates how timely, necessary and life-saving the 50 ventilators donated by the USAID have been to the treatment of patients in Mongolia.

ЭМЧ, СУВИЛАГЧ НАРТ СУРГАЛТ ЯВУУЛЖ БАЙНА

Хүүхдийг Ивээх Сан АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр "Монгол Улсад КОВИД-19-ийн хариу арга хэмжээг сайжруулахад техникийн туслалцаа үзүүлэх, зорилтод нийцүүлэн тархварзүйн хяналтыг дэмжих" (EpiC) төслийг АНУ-ын FHI 360 (Family Health International) байгууллагатай хамтран Архангай, Баянхонгор, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Өвөрхангай, Говьсүмбэр, Хэнтий, Сэлэнгэ, Орхон, Завхан гэсэн 11 аймагт хэрэгжүүлж байгаа юм. Төслийн хүрээнд цар тахлын үеийн эрчимт эмчилгээ, зохиомол амьсгалуулалтын дэвшилтэт технологи арга, аргачлалд эмч, сувилагчдыг сургаж байна. 2021 онд 20 аймгийн нэгдсэн эмнэлгийн 91 эмч мэргэжилтнүүд энэхүү сургалтанд хамрагдсан билээ. Эрүүл мэндийн төсөл нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд, сумын эрүүл мэндийн төв дэх КОВИД-19-ийн халдварын үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байгаа эмч, эмнэлгийн ажилтны чадавхыг сайжруулах мөн амьсгалын аппаратын хэрэглээ, хүчилтөрөгчийн экосистемийг бэхжүүлэх болон КОВИД-19-ийн халдварын амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд эмнэлгийн ажилчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд техникийн туслалцаа үзүүлэх зорилготой юм.



Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Мэдээгүйжүүлэлт эрчим эмчилгээний тасгийн унтуулгын сувилагч Б.Энхцэцэг

B.Enkhtsetseg, anesthesiologist nurse at Anesthesia and Intensive Care Unit, Dornod Regional Diagnostic and Treatment Center

“

Сувилагчаар 16 жил ажиллаж байна. Сургалтаар амьсгалын аппаратны ажиллах зарчим, өвчтөнөө хэрхэн байрлуулах зэрэг чадварууд олгосон байгаа. Хэрэгтэй, үр дүнтэй сургалт байсан. Үүний дараа сувилагчид амьсгал дэмжих ажиллагаанд суралцаж чадваржсан. Энэ сургалтыг эрчимт эмчилгээний сувилагчдаас гадна онцгой нөхцөлд ажилладаг бусад мэргэжлийн сувилагч нарт явуулах шаардлагатай гэж бодож байна.

”

“

I have been working as a nurse for 16 years. The training provided information on how the ventilator works and how to position patients on a ventilator. It was useful and effective training that enabled nurses to provide best practice ventilatory support. I think that this training should be provided to all nurses as well as intensive care nurses.

”

DOCTORS AND NURSES INVOLVED IN THE TRAINING

Funded by the United States Agency for International Development (USAID), Save the Children implements the project “Meeting Targets and Maintaining Epidemic Control (EpiC)” in Arkhangai, Bayankhongor, Darkhan-Uul, Dornod, Dornogovi, Uvurkhangai, Govisumber, Khentii, Selenge, Orkhon and Zavkhan aimags in partnership with FHI 360 (Family Health International). Within the project, doctors and nurses have been effectively trained in advanced techniques and methods of intensive care and artificial ventilation that could be applied during the

pandemic. In 2021-2022, 114 doctors and specialists from 21 provincial and 9 district’s general hospitals participated in the training that aimed to improve the capacity of doctors and medical staff providing health services during the pandemic in aimag and district general hospitals and soum health centers, to provide technical assistance to strengthen the use of ventilators and oxygen ecosystems, and to increase the knowledge and skills of medical staff to provide life-saving care for patients confirmed with the Covid-19 infection.



Save the Children

🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Аризона төв, 4-р давхар

☎ +976-11-329365, +976-11-329371

📠 +976-11-329361



www.savethechildren.mn



Save the Children in Mongolia



[hairaar.ulgerley](https://www.instagram.com/hairaar.ulgerley)



Save the Children MN



Save the Children in Mongolia